

БАТЛАВ

ЗАХИАЛАГЧ:

ЦУС СЭЛБЭЛТ СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ
Н.ЭРДЭНЭБАЯР

Дугаар № 2016 он 01

“Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төв”-д үзлэгийн бээлийн нийлүүлэх гэрээ.

НИЙЛҮҮЛЭГЧ:

МӨНХИЙН ТУН ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ш.МУХАМЕДЖАН



Улаанбаатар хот

Нэг талаас *Цус сэлбэлт судлалын үндэсний төв* (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас *Мөнхийн тун ХХК* (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож 2016 оны 02 сарын 16-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
- 1.2 Захиалагч нь “Цус Сэлбэлт Судлалын Үндэсний төвд цусны хүүдий, оношлуур, эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх 2016 он 01” дугаартай тендерийн “Үзлэгийн бээлийний 13-р багцын (цаашид “бараа” гэх) нийт **15,210,000** (арван таван сая хоёр зуун арван мянган) төгрөгөөр (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
- 1.3 Захиалагч нь барааны нийлүүлэлтийг нийт **15,210,000** төгрөгийн төвлөрсөн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
- 1.4 Нийлүүлэгч нь барааг 2016 оны 02 дугаар сарын 16-наас 2016 оны 06 дугаар сарын 01-ний дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
- 1.5 Дор дурдсан бичиг баримт нь гэрээний хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:
 - 1.5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

- 1.5.2 Бусад шаардлагатай баримт бичиг¹;
- 1.5.3 Тендер ба үнийн хуваарь;
- 1.5.4 Гэрээний тусгай нөхцөл;
- 1.5.5 Гэрээний ерөнхий нөхцөл;
- 1.5.6 Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
- 1.5.7 Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

- 1.6 Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.
- 1.7 Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг хариуцлага хүлээж байна.
- 1.8 Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

- 2.1. Захиалагч нь 1.4-т дурдсан хугацаанд нийлүүлэгдсэн барааг хүлээн авч, хүлээн авсан тухай баримт бичиг болон нийлүүлэгчийн нэхэмжлэхийг үндэслэн 20 хоногийн дотор төлбөрийг нийлүүлэгчийн данс руу шилжүүлэх үүрэгтэй.
- 2.2. Захиалагч нь гэрээгээр тохиролцсон төлбөр төлөх хугацааг хэтрүүлсэн тохиолдолд нэхэмжилсэн нийт үнийн дунгийн 0.1%-тай тэнцэх алдангийг хэтрүүлсэн хоног тутамд нийлүүлэгчид төлөх үүрэгтэй.
- 2.3. Захиалагч нь нийлүүлэгчийн нийлүүлсэн бараа техникийн тодорхойлолтын шаардлага хангагүй, эсвэл нийлүүлэгч нь гэрээний бусад үүргээ биелүүлээгүй тохиолдолд нийлүүлэгчид бичгээр мэдэгдсэнээр гэрээг бүхэлд нь болон хэсэгчлэн цуцлах үүрэгтэй.

Гурав. Гүйцэтгэгчийн эрх үүрэг

- 3.1. Нийлүүлэгч нь гэрээний бүх нөхцөл, техникийн тодорхойлолтонд нийцсэн барааг нийлүүлэх үүрэгтэй.
- 3.2. Барааны шошго нь тендерийн материалд заасны дагуу англи хэл дээр бичигдсэн байна.
- 3.3. Нийлүүлэгч нь барааг шаардлагын дагуу зөв тээвэрлэн хүргэх нөхцөлийг хангах асуудлыг бүрэн хариуцана.
- 3.4. Нийлүүлэгч нь барааны тоо хэмжээг дутаах, нийлүүлэх хугацааг хоцроо асуудал гаргасан тохиолдолд гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээгээр хоногийн 0,1%-ийн алдангийг захиалагчид төлнө.

Дөрөв. Хүчинтэй хугацаа

Гэрээ нь нийлүүлэгч барааг захиалагчид хүлээлгэн өгч, төлбөрийг дансаар хүлээн авч дуусах хүртэл хүчинтэй байна.

Тав. Бусад зүйл

- 5.1. Талууд гэрээнд холбогдох асуудлаар албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
- 5.2. Гэрээ хэрэгжүүлэхтэй холбоотой үүссэн аливаа маргааныг талууд зөвшилцлийн журмаар шийдвэрлэх ба зөвшилцэх боломжгүй болсон тохиолдолд ХАҮТ-ын дэргэдэх арбитрын шүүхээр шийдвэрлүүлнэ.

Уг гэрээ нь монгол хэл дээр З хувь хийгдсэн ба талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчинтэй болно.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Цус Сэлбэлт Судлалын Үндэсний
Төвийн Ерөнхий Нягтлан бодогч Д.Гүнжээ

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Энхтайваны
өргөн чөлөө-13, С.Зоригийн гудамж

Утас: 326504, 312857, Факс: 976-11- 312857

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ :

Мөнхийн тун ХХК-ийн
эм зүйч Θ.Ариунзаяа

.....
Θ. Ариун зал - 2

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 3-р хороо
Мандухай зочид буудлын хажууд өөрийн байр
Утас: 70115653 , Факс: 976-11-312951

8130101 → Төв салуулт

Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн бөтөөд импортоор орж ирэх барааны үнийн хуваарь

ОГНОО: 2016.02.16

НТШ-ЫН ДУГААР: 2016 он 01

ҮЗЛЭГИЙН БЭЭЛИЙН БАГЦ №13.

№	Бүтээгдэхүүний нэр	Олон улсын буюу өрөнхий нэршил	Эмийн хэлбэр	Савалтны хэмжээ	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгж чиэ	Нийт чиэ
1	Эмнэлгийн нэг удаагийн хэрэглээний үзлэгийн бээлийн 1	Gloves without powder	Бээлий	Хайрцаг / 1 хайрцагт 50 хос/	Ширхэг 130000 хос буюу 2600 хайрцаг	117	15,210,000	15,210,000
	Нийт							

БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ-ҮЗЛЭГИЙН БЭЭЛИЙ БАГЦ №13

Код	Бүтээгдхүүний нэр	Эмийн олон улсын буюу өрөнхий нэршил	Эмийн хэлбэр	Савалтын хэмжээ	Шаардагдаж буй хэмжээ	Нийтийн хувваарь	
						2016 оны 2 сар	2016 оны 6 сар
1	Эмнэлгийн нэг удаагийн хэрэглээний үзлэгийн бээлий	Gloves without powder	Бээлий	Хайрцаг / 1 хайрцагт 50 хос/	130000 хос буюу 2600 хайрцаг	65000 хос буюу 1300 хайрцаг	65000 хос буюу 1300 хайрцаг